



## “ТАВАН ТОЛГОЙ ТҮЛШ” ХХК ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2020 оны 11 сарын 19 өдөр

Дугаар А/162

Улаанбаатар хот

### “Ажлын байрны ашиглалтын зааварчилгаа” батлах тухай


Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Таван толгой түлш” ХХК-ийн Сайжруулсан шахмал түлшний үйлдвэрийн ажлын байрны онцлогт нийцсэн “Аюулгүй ажиллагааны ерөнхий зааварчилгаа”-г 1 дүгээр хавсралтаар, “Өргөх төхөөрөмж ашиглан гүйцэтгэх ажлын аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г 2 дугаар хавсралтаар, “Оффисын ажилтны аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г 3 дугаар хавсралтаар, “Гар цахилгаан багаж ашиглан гүйцэтгэх ажлын аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г 4 дүгээр хавсралтаар, “Гагнуурчны аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г 5 дугаар хавсралтаар, “Слесарийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г 6 дугаар хавсралтаар, “Үйлчлэгчийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г 7 дугаар тус тус баталсугай.
2. Батлагдсан зааварчилгааг үйл ажиллагаанд мөрдүүлж ажиллахыг Үйлдвэрлэлийн албаны дарга, Ерөнхий инженер, Ерөнхий механик, Хөдөлмөр аюулгүй байдал эрүүл ахуйн хэсэгт тус тус үүрэг болгосугай.
3. Зааварчилгааны хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хууль эрх зүй, аудитын алба /Л.Батбаяр/-д даалгасугай.



ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ




М.ГАНБААТАР

	Гар цахилгаан багаж ашиглан гүйцэтгэх ажлын аюулгүй ажиллагааны зааварчилгаа	ТТТ-АА-03	БАТЛАВ ГҮЙЦЭТГЭХ АЖИРАЛ ..... / М.Ганбаатар
		Хувилбар: 1	Баталсан огноо: 2020 оны 11 сар 2 өдөр
		Тушаал № А/162	ТТТ ТӨХИРГӨМ ХӨШТӨН

## ГАР ЦАХИЛГААН БАГАЖ АШИГЛАН ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА

Ажилтан	Гарын үсэг	Өвөг нэр	Албан тушаал	Төлөв
Хянасан:		М.Анхныбаяр	ХАБЭА-н хэсгийн дарга	Тэмдэг
Боловсруулсан:		Э.Амарсайхан	ХАБЭА-н ажилтан	

	Гар цахилгаан багаж ашиглан гүйцэтгэх ажлын аюулгүй ажиллагааны зааварчилгаа	ТТТ-АА-03	БАТЛАВ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ /...../ М.Ганбаатар
		Хувилбар: 1	Баталсан огноо: 2020 он ....сар .... өдөр
		Тушаал №	

# ГАР ЦАХИЛГААН БАГАЖ АШИГЛАН ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА

Ажилтан	Гарын үсэг	Овог нэр	Албан тушаал	Төлөв
Хянасан:	/...../	М.Анхныбаяр	ХАБЭА-н хэсгийн дарга	Тэмдэг
Боловсруулсан:	/...../	Э.Амарсайхан	ХАБЭА-н ажилтан	

Гар цахилгаан багаж ашиглан гүйцэтгэх ажлын аюулгүй ажиллагааны зааварчилгаа	ТТТ-АА-03
	Хувилбар: 1

БАРИМТ БИЧГИЙН ТҮҮХ			
Хувилбар	Өөрчлөлтийн утга	Боловсруулсан	Тушаалын дугаар/Огноо
1			

Гар цахилгаан багаж ашиглан гүйцэтгэх ажлын аюулгүй ажиллагааны зааварчилгаа	ТТТ-АА-03
	Хувилбар: 1

## Агуулга

Нэг. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ерөнхий шаардлага .....	4
Хоёр. Ажил эхлэхийн өмнөх аюулгүйн шаардлага .....	4
Гурав. Ажил гүйцэтгэх үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа .....	5
Дөрөв. Ажил дууссаны дараах аюулгүйн шаардлага .....	6

Гар цахилгаан багаж ашиглан гүйцэтгэх ажлын аюулгүй ажиллагааны зааварчилгаа	ТТТ-АА-03
	Хувилбар: 1

**НЭГ. ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН  
ЕРӨНХИЙ ШААРДЛАГА**

- 1.1. Ажилтан тухайн багажийг ашиглахад шаардлагатай хувийн хамгаалах хэрэгслээр хангагдсан байна. Хувийн хамгаалах хэрэгслийг ашиглахгүйгээр багаж ажиллуулахыг хориглоно.
- 1.2. Ажилтан ашиглаж буй багаж хэрэгслийг задлах, засвар, үйлчилгээ хийхийг хориглоно. Зөвхөн эрх бүхий хүн зориулалтын байранд цахилгаан хүчдэлээс заавал салгасан нөхцөлд засвар, үйлчилгээг хийнэ.
- 1.3. Багаж хэрэгсэлд тогтмол үзлэг шалгалт хийж, шаардлагатай засвар үйлчилгээ, тохируулга, баталгаажуулалт хийсэн байна.
- 1.4. Аюулгүйн хамгаалалтын тоноглолгүй, бүрэн бус багаж ашиглахыг хориглоно.
- 1.5. Баталгаажуулалт хийгдээгүй, ашиглах зөвшөөрөлгүй, бүрэн бус, эвдрэлтэй, цахилгаан дамжуулах утас, тэжээлийн залгуур (вилк), шнур, гох, аюулгүйн тоноглол нь гэмтэлтэй багаж хэрэгслийг ашиглахыг хориглоно.
- 1.6. Цахилгаан багаж хэрэгслийг ус ашиглан цэвэрлэгээ хийхийг хориглоно.
- 1.7. Багаж хэрэгслийн зориулалтын бусаар хэрэглэхийг хориглоно. Ажилтан ашиглах багаж хэрэгслийнхээ зориулалт, бүтэц, ажиллагаа зэргийг мэддэг байх. Шаардлагатай үед аюулгүй болгох арга барилд суралцсан байна.

**ХОЁР. АЖИЛ ЭХЛЭХИЙН ӨМНӨХ АЮУЛГҮЙН ШААРДЛАГА**

- 2.1. Хийх ажилд хэрэглэгдэх багаж хэрэгсэл, шаардлагатай хувийн болон хамтын хамгаалах хэрэгслийг бэлдэж хувийн хамгаалах хэрэгслийг бүрэн зөв өмсөж хэрэглэсэн байна.
- 2.2. Ажилтан багажийг ажиллуулж эхлэхийн өмнө дараах зүйлс бүрэн бүтэн, гэмтэлгүй хэвийн ажиллагаатай байгаа эсэхийг шалгана:
  - Багажны цахилгаан дамжуулах утас, тэжээлийн залгуур, шнур, гох;
  - Аюулгүйн тоноглол;
  - Утаа, үнэр гарах;
  - Чимээ, цохилт, чичиргээ үүсэх;
  - Бүрэн бүтэн байдал, хэвийн ажиллагаа;
- 2.3. Үзлэгээр эвдрэл, гэмтэл, зөрчил илэрсэн тохиолдолд тухайн багажийг ажилд ашиглахыг хориглоно. Удирдлагад болон засварын хэсэгт мэдээлж засварлуулж, зөрчлийг арилгуулсан, засварлах боломжгүй багажийг шинээр солиулсны дараа ажлыг эхлүүлнэ.

Гар цахилгаан багаж ашиглан гүйцэтгэх ажлын аюулгүй ажиллагааны зааварчилгаа	ТТТ-АА-03
	Хувилбар: 1

**ГУРАВ. АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ҮЕИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ  
ЗААВАРЧИЛГАА**

- 3.1. Багаж хэрэгслийн цахилгаан дамжуулах утас, тэжээлийн залгуур зэрэгт гэмтэл учруулахаас сэргийлж хүн, механизмын зам дээр, чийгтэй нойтон гадаргууд, өргөсөн ачааны доор орхихгүй, бусад эд зүйл, тоног төхөөрөмжийн эд ангид орооцолдох, татагдахаас хамгаалж аль болох өлгөж байрлуулсан байна.
- 3.2. Гар цахилгаан багажтай ажиллахдаа ажилтан тэнцвэрээ олж, тогтвортой байдалд ажиллана.
- 3.3. Жижиг, хөдөлгөөнд орж болох деталийг боловсруулахдаа заавал тискийнд хавчуулж, хөдөлгөөнгүй болгож байж боловсруулалт хийх.
- 3.4. Цахилгаан багаж хэрэгслээр нойтон, мөстсөн деталийг боловсруулахыг хориглоно.
- 3.5. Гар цахилгаан багажаар аливаа шингэн дусал гоожих нөхцөлд болон бороо, цастай үед ажиллахыг хориглоно.
- 3.6. Гар цахилгаан багажийг зөөх, ажил түр завсарлах эсвэл дуусахад цахилгаан тэжээлээс салгасан байна.
- 3.7. Цахилгаан багаж хэрэгслийг цахилгаанд залгаастайгаар эзэнгүй орхих, түүнтэй ажиллах эрхгүй хүнд дамжуулахыг хориглоно.
- 3.8. Цахилгаан багажид түлхүүр, бусад эд зүйл уяж зүүхийг хориглоно.
- 3.9. Багаж хэрэгслийг техникийн хүчин чадлыг хэтрүүлэх, зориулалтын бусаар ашиглахыг хориглоно.
- 3.10. Эргэлдэж байгаа багажид гараар хүрэхийг хориглоно.
- 3.11. Ажиллаж байгаа багаж хэрэгслийн тоос шороог цэвэрлэхийг хориглоно.
- 3.12. Ажилтан ашиглаж буй гар цахилгаан багаж хэрэгсэлд эвдрэл гэмтэл, доголдол үүссэн эсвэл бусад тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, тэдгээрийн эд ангид гэмтэл учруулсан тохиолдол ажиллагааг зогсоож, цахилгааны эх үүсвэрийг салгаж шууд удирдлага болон холбогдох албан тушаалтанд мэдээлэх үүрэгтэй.
- 3.13. Эвдрэл гэмтэл, догол гарсан багаж хэрэгслийг бүрэн засварлуулж дууссаны дараа ашиглах зөвшөөрөл олгосон тохиолдолд ашиглах ба боломжтой бол шинэ багаж хэрэгслээр солиулж авна.
- 3.14. Гар цахилгаанд багаж хэрэгсэлд хүний бие, эд эрхтэн, хувцас хэрэгсэл, бусад тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, тэдгээрийн эд анги өртөх гэмтэхээс урьдчилан сэргийлж аюулгүй байдлыг хангаж анхаарал болгоомжтой ажиллана.
- 3.15. Гар цахилгаан багаж хэрэгсэл ашиглан ажиллаж байгаа ажилтан өөрийн биед гэмтэл учирсан, биеийн байдал муудсан тохиолдолд гар цахилгаан багажийг унтрааж, ажлаа зогсоож, багаж хэрэгслийг цахилгаан тэжээлээс салгаж шууд

Гар цахилгаан багаж ашиглан гүйцэтгэх ажлын аюулгүй ажиллагааны зааварчилгаа	ТТТ-АА-03
	Хувилбар: 1

удирдлага болон эмчид мэдээлэл өгнө. Анхны тусламж иртэл өөрт боломжийн хэрээр анхны тусламж үзүүлэх, боломжгүй бол бусдаас тусламж хүснэ.

#### **ДӨРӨВ. АЖИЛ ДУУССАНЫ ДАРААХ АЮУЛГҮЙН ШААРДЛАГА**

- 4.1. Ашигласан багаж хэрэгслийг цахилгаан тэжээлээс салгаж, тоос шороог цэвэрлэж, зориулалтын сав хайрцаг, байранд хураана.
- 4.2. Ашигласан багаж хэрэгслийг дараагийн ээлжийн ажилтанд хүлээлгэн өгөх шаардлага гарвал тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл хүлээлцэх акт үйлдэнэ.
- 4.3. Ажил гүйцэтгэх хугацаанд гарсан багаж хэрэгслийн эвдрэл гэмтэл, догол, түүнд хийгдсэн засвар, үйлчилгээ болон бусад аюултай тохиолдлын талаар шууд удирдлагад мэдээлэл өгнө.